

Хятан хувцасны хэв маягийн зарим онцлогийн тухай

Сунина^{1,*}

Товч агуулга: Монголын өндөрлөгт төр улсаа байгуулж явсан Хятаны нүүдэлчид түүхийн явцад эх газрын хүйтэн сэрүүн уур амьсгал, ахуй амьдралын хэв маягтаа зохицсон үндэсний өвөрмөц хувцсыг бий болгожээ. Мал амьтны арьс үслэг, ноос ноолуур зэргийг гол түүхий эд болгон ашигладаг бөгөөд Төв Хятадын суурин соёлын хувцаснаас эрс ялгаатай байв. Энэхүү өгүүлэлд Хятан нарын хувцасны хөгжил хувьсал, хэв маягийн зарим онцлогийг харьцуулан судлахыг оролдсон байна.

Түлхүүр үг: Хятан, хувцас, бунхны ханын зураг

Удиртгал

Хувцасны шинэчлэл, өөрчлөлт нь соёлын солилцоо, улс, үндэстний нэгдмэл байдлын нэг тод шинж тэмдэг бөгөөд тухайн улс, үндэстний соёлын бэлгэдэл юм. Мөн оюун ухааны соёлын биелэл нь хүмүүсийн гоо зүйн үзэл баримтлал, үзэл суртлыг тод тусгаж, эртний нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, шашин шүтлэг, соёл, урлагийн өөрчлөлт, дэвшлийг харуулдаг. Монголын өндөрлөгт үндэстний хувцасны хөгжлийн явцад Байлдаант улсын үеийн “Ху хувцас өмсөн, морь унаж, нум харвах” нь Өмнөд, Умардын төрийн хувцасны соёлын солилцоо, нэгдлийн үндэс суурийг тавьсан юм. Вэй, Жин, Өмнөд, Умард төрийн үеийн хувцас уусалцалд нь Тан улсын Төв Хятадын ёс зүйн тогтолцоогоор төлөөлүүлсэн хувцасны систем ба Сяньбигийн, Баруун Ху хувцасны системийг хосолсон “Хос зуршил” нь хувцасны соёлын олон талт байдлын үндэс суурь болжээ.

Баруун Жоу улсын сүүл үеэс Чунчью Байлдаант улсын дунд үе хүртэлх Сицзядианы соёлын дээд давхаргын (夏家店上层文化) булшнаас хүрэл савыг ороосон торгон даавууны ул мөр илэрчээ. Ляо, Тангуд, Алтан улс, Юань улсын үеийн торгон даавуу нь төрөл, гоёл чимэглэлийн хэв маяг, нэхэх арга барилын хувьд голчлон Тан, Сүн улсын соёлын элементүүд, түүнчлэн Төв Ази, Баруун Азийн соёлын нөлөөг агуулсан байв. Тэдгээрийн дотроос Хятан нарын хувцас өвөрмөц хэв маягийг бүрдүүлсэн. Хятан нар эрэгтэй эмэгтэй, хөгшин залуугүй морь унаж, харвахдаа гарамгай. Тиймээс хувцасны хэлбэр нь морь унах, нум сум харвахад тохиромжтой байв. Хятан нарын мал малжих, загас барих, ав хоморго хийх зэрэг нь зөвхөн аж ахуйн үйл ажиллагаа төдий бус цэргийн сургуулилт

тул дайн болбол хурдан цэрэг байгуулж чаддаг. Ийм амьдралын нөхцөл, сорилт нь Хятан нарын хувцасны соёлд шууд нөлөөлсөн байна (Ян Руовэй 1992).

“Шан Шу Жэнг и”-д “Хуася”-д (《尚书正义》注“华夏”) тэмдэглэхдээ: “Гоёмсог хувцсыг “Хуа” гэж, их улсыг “Ши” гэж нэрлэдэг” гэжээ. Хятадын соёлд хувцас нь зөвхөн хувцас биш, харин ёс зүй, эрхэмсэг, хүндэтгэлийг харуулах үүргийг гүйцэтгэдэг, энэ нь Хан үндэстний хувцасны хэлбэрт тусгагдсан байдалд тод илэрнэ. Гэсэн хэдий ч хувцасны хэлбэр нь хувиралтгүй биш бөгөөд түүний өөрчлөлт нь үндэстэн угсаатны солилцоо, харилцан үйлчлэлийн түүхтэй нэгдмэл байдаг (Жун Чунхуй 2019).

Ляо улсын хувцас нь “Умард нутгийн үндэсний тогтолцоо, өмнө зүгт Хятад үндэстний систем” байснаа “Төрийн ёслол, үйл ажиллагаанд хятад хувцас өмсөх” болж өөрчлөгдсөн. Ляо улсын эхэн үед умард, өмнөд нутгийн ёс заншлаар тусдаа хувааж зассанаас, хувцас, малгайн тогтолцоог бий болгосон. “Ляо улсын түүх, Ивэй Жи”-гээс (《辽史·仪卫志二》) үзвэл, Ляо улсын эхэн үед умард тогтолцооны хувцас нь Хятанчуудын ёс заншлын дагуу эрэгтэй, эмэгтэй үндэсний хувцас өмсөж, албан тушаалтнууд болон жирийн иргэд нэг тогтолцоотой байжээ. Өмнөд системд хятад үндэстэн өөрийн үндэсний хувцсаа өмсдөг байв. Хятанчууд Ляо гүрнийг байгуулсны дараа тэд умард болон өмнөд хоёрыг хуваасан “титэм, бүсний” тогтолцоог бүрдүүлж эхэлсэн бөгөөд өмнөд системийн хувцас нь Хойд Жинь улсын тогтолцоог өвлөн авч, Ляо улсын дунд үе хүртэл өөрчлөгдсөнгүй. “Цянхенгийн (乾亨) дараа умард зүгийн гуравдугаар болон түүнээс дээш зэргийн түшмэл хятад хувцас өмсдөг байсан бол Чунсигийн (重熙) дараа төрийн ёслол, үйл ажиллагаанд хятад хувцастай хослуулах” дүрэмтэй болжээ (Тод 1974).

Ляо улсын дунд үеэс хойш Хятан, Хятад үндэстний хоорондын солилцоо аажмаар гүнзгийрэхийн хирээр

¹ МУИС, ШУС, Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн докторант

* Холбоо барих зохиогч: ajjg123123@163.com

Хятан нар Хятад үндэстний хувцас өмсөж, Хятадууд бас Хятан хувцас өмсөх болжээ. Ляо улсын хувцасны тогтолцоонд гарсан өөрчлөлт нь тухайн үеийн ордон ба ард түмний соёлын өргөн хүрээний солилцоо, харилцан нөлөөг харуулж байдаг.

Хятан хувцасны түүх ба гарал үүсэл

Хятанчууд бол Сяньби үндэстний нэг салбар юм. Хань улсын түүхийн ном зохиолд тэмдэглэснээр: Хятан ба Юйвэнь Сяньби (宇文鲜卑), Кумоси (库莫奚人) нар мал малжиж амьдарч байсан гэж тэмдэглэсэн. НТ 344 онд Өмнөд Янь улсын (南燕国) удирдагч Мурун (Хуан慕容皝) Юйвэнь Сяньби руу довтлоход сяньби үндэстнээс таран бутарч тусгаарлагдсан хэсэг өөрийгөө “Хятан” хэмээн нэрлэжээ (У Байчун, Суожу 1990). Хятан нар нэг хэсэг Түрэг, Уйгурын захиргаанд явсан ба Тан улс Анлушан (安祿山), Аньшийн бослогын (安史之乱) дарсны дараа Хятан, Кумосийн хамт хагас тусгаар улс болжээ. Жил бүр алба татвар төлж, Тан улстай харилцдаг байв. Энэ үеийн харь үндэстний төрийн хувцасны янз байдал “Жи Гун Ту” (职贡图) хэмээх зургийн хуулбаруудад үлдсэн байдаг. Ляо улс нь Хятадын соёл, Бохай соёлыг (渤海国) маш ихээр шингээж авсан. Бохай улсыг устгасны дараа Бохайгаас амьд үлдсэн олон тооны хүмүүс Ляо улсын дээд нийслэл болон зүүн нийслэлийн ойролцоох муж, хошуунд шилжин амьдарч байжээ. Хятадын Юй Юйны арван зургаан мужийн (幽云十六州) Сүн улстай худалдаа арилжаа хийж байдгаас үзвэл, Хятад үндэстний соёл нь дайн байлдааны үед болон энх тайван цагт ч Ляо улсад асар их нөлөө үзүүлжээ (Редакцийн хэлтсээс найруулсан 1992).

Хятаны энэхүү “нэг улс, хоёр систем” тогтолцоо нь зөвхөн улс төр, эдийн засагт нөлөөлөөд зогсохгүй соёл, тэр дундаа хувцасны соёлд ч гэсэн агуулагддаг. Нөгөө талаараа тэр нь Хятанчуудын хувцасны соёлыг хамгаалсан байдаг. Хятан үндэстэн бүрэлдэн хөгжих явцад хувцас нь өөрчлөгдөн хувьсаж ирсэн бөгөөд үүнийг дараах үе шатуудад хуваана. Үүнд:

Хятаны өвөг дээдсийн өмсдөг Ху хувцасны хэлбэрүүд. Хятанчуудын өвөг дээдсийн Дунху хувцасны хэв маяг нь умард нүүдэлчдийн амьдралын хэв маяг, амьдарч буй орчны хэрэгцээ шаардлагад тохирсон практик, уян хатан байдлыг илэрхийлдэг. Хувцасны материалын хувьд хүйтэн сэрүүн уур амьсгалаас хамгаалахын тулд зузаан материал ашиглах шаардлагатай байсан. Ан агнуур, мал малжих, нүүдэлч амьдралын хэв маяг нь хувцасны материалын хэрэгцээнд тохирсон материалаар хангадаг. Хятан хувцас нь ихэвчлэн ноос, арьсаар хийгдсэн байдаг. Эдгээр материалууд нь өндөр дулаалгатай, удаан эдлэгтэй бөгөөд хүйтэн уур амьсгалд нэн тохиромжтой. Хятан хувцас нь гоёл

чимэглэлийн энгийн, практик байдлыг эрхэмлэдэг боловч язгууртны байр суурийг илэрхийлсэн металл гоёл чимэглэл, ялангуяа зах, ханцуйвч гэх хэсэгт хэрэглэнэ. Хятаны өвөг дээдсийн хувцас нь “нутгийн нөхцөлд тохируулан хэрэглэх” гэсэн хятан нарын хувцасны мэргэн ухааныг илэрхийлж, Монголын өндөрлөгийн нүүдэлчин ард түмний өвөрмөц онцлогийг бүрдүүлсэн байдаг.

Өмнөд, Умардын төрийн үе дэх Хятан хувцасны өөрчлөлт. Өмнөд, Умардын төрийн үед Хятаны хувцас ихээхэн өөрчлөлтийг туулсан нь зөвхөн өөрийн нийгмийн хэлбэрийн хувьсалд нөлөөлсөн төдийгүй Хятад, Сяньби зэрэг угсаатны соёлд гүн гүнзгий нөлөөлсөн. Өмнөд Умардын төрийн эхэн үед Хятан нар нүүдэл нийгэмд байсаар байсан бөгөөд хувцас хунар нь морь унаж сур харвах, хүйтнийг тэсвэрлэх, дулаан байлгахад зориулагдсан, хувцасны загвар нь энгийн бөгөөд практик, ихэвчлэн үслэг эдлэлээр хийгдсэн, өнгө нь ихэвчлэн байгалийн өнгөтэй юм (Тод 1974). Төв Хятадтай харилцаа улам бүр нэмэгдэж, Хятаны нийгэм аажмаар газар тариалан, мал аж ахуйг хослуулсан суурин амьдралд шилжсэнээр хувцас хунар аажмаар боловсронгуй, нарийн оёдолтой тэгш хөгжиж байв. Өмнөд, Умардын төрийн үед Умард Вэй, Хойд Ци болон бусад Төв Хятадын дэглэмүүдтэй харилцаа холбоо гүнзгийрсний улмаас хятан нарын хувцас нь Хятад үндэстэн болон бусад Умард угсаатнаас хувцасны элементүүдийг өөртөө зээлж авч эхэлсэн. Түүгээр ч зогсохгүй Хятан нар Төв Хятадын нутгаас янз бүрийн замаар авсан торго, торгон хатгамал хувцас хунартаа ашиглах болжээ. Язгууртны хувцас нь Хятад үндэстний соёлд онцгой нөлөөлөгдсөн бөгөөд хэв маяг нь илүү гоёмсог, гоёл чимэглэлтэй байв. Эрэгтэй хувцас нь ихэвчлэн дээл, бүсний загвартай байдаг бол эмэгтэйчүүд үсний нарийн тансаг гоёл чимэглэл, ээмэг зүүж эхэлсэн, хувцаслалтын хэв маяг нь гоо сайханд илүү анхаарал хандуулдаг. Өмнөд, Умардын төрийн үеийн Хятан хувцасны өөрчлөлт нь нийгмийн эдийн засаг, соёлын дэвшлийг илэрхийлээд зогсохгүй Хятан үндэстний дан малжил амьдралаас аажмаар газар тариалан, мал аж ахуй бүхий нийгмийн хэлбэрт шилжсэнийг харуулна. Энэ нь Ляо улсын хожуу үеийн Хятан хувцасны үндэс суурийг тавьсан байна.

Сүй, Тан улсын үеийн Хятан хувцасны соёл болон Төв Хятадын солилцоо, нэгдмэл байдал. Сүй, Тан улсын үе нь Хятан үндэстний хувьд хөгжлийн чухал үе байсан бөгөөд тухайн үед Хятан нь Төв Хятадын дэглэмтэй харьцангуй ойр дотно харилцаатай байв. Тан улсын үед Хятан нь Тан улсын төв засгийн газрын харьяанд байсан орон нутгийн засаг захиргаанд захирагдаж байсан. Хятан үндэстний удирдагчид Тан улсын засгийн газраас цол хэргэм олгож, бас Тан улсын хааны угсаатай ургийн холбоо байгуулжээ. Тангийн гүнжийн авчирсан нэхмэлийн технологи, торгон

бүтээгдэхүүн нь Хятаны язгууртнуудын хувцас засалд ихээхэн нөлөөлсөн. Язгууртнуудын торгон хувцас нь ихэвчлэн Тан улсын төрийн шагнал урамшуулал, эсвэл Төв Хятадтай хийсэн худалдаа солилцооноос үүсэлтэй байв. Энэ үеийн Хятанчуудын хувцасны хэв маяг Төв Хятадтай харьцангуй ойролцоо байсан ч үндэсний хувцасны буруу энгэр, захын уламжлалаа хадгалагдан үлджээ. “Хятан улсын шастир”-д: “Бохайн ахлагч, 10.000 гаруй морьтон цэргүүддээ хятан хувцас өмсгөв” гэж тэмдэглэжээ (Е Лонли 1986: 225). Анхны үе шатанд нэхмэл бөс хувцасны бага хувийг эзэлдэг байсан, хувцасны материал нь ихэвчлэн үслэг эдлэл байсан ч яваандаа язгууртны хувцсанд торго даавууг улам бүр ашиглах болов.

Хятан хувцасны хэв маягийн зарим онцлог

Хятанчуудын өвөрмөц хувцасны гол төрөл бол эрэгтэй, эмэгтэй адилхан өмсдөг дээл юм. Эрэгтэй хүний хувцас нь үйлдвэрлэл, амьдралын онцлогийг илүү сайн тусгаж чаддаг тул энд Хятан эрчүүдийн дээлийг жишээ болгон ашигласан болно. Ляо улсын эхэн үеийн ханын зургуудад сайд нар, жирийн иргэд ихэнх нь буруу энгэртэй хувцас өмсдөг байв. Гэсэн хэдий ч угсаатны нэгдлийн чиг хандлага хүчирхэгжсэнээр Хятанчууд буруу энгэртэй хувцас өмсдөг заншлаа хадгалсаар байсан ч аажмаар Хятад


хувцасны онцлогтой зөв энгэртэй хувцас гарч ирэв. Хятаны бунхны ханын зурагт буруу, зөв энгэртэй хувцас зэрэг илэрсэн жишээ цөөнгүй байдаг. БНХАУ-ын Хэбэй мужийн Сюанхуа хотын Сябалигийн (河北宣化下八里) 10-р дугаар булшинд дөрвөн эрэгтэй, эмэгтэй зөөгч цай бэлдэж байгаа зураг (Хэбэй мужийн соёлын дурсгалын судалгааны хүрээлэн 2001), Аохань хошуун дахь Яншаны (敖汉旗羊山) оршуулгын газрын 3-р булшны хашааны баруун хананд байгаа хоол хийх зураг (Аохань хошууны музей 1999) дээрх хятан зарц нарын хувцсанд Ляо улсын дунд болон хожуу үеийн буруу, зөв энгэртэй Хятан хувцасны хэв маягийн нийлсэн үзэгдлийг бүрэн тусгасан байна. Түүнээс гадна, Монгол Улсын Баянхонгор аймгийн Дугуй Цахир, Ховд аймгийн Үзүүр гялангаас олдсон X-XII зууны зургаан дээлийг үзэхэд хийц загварын хувьд цөм Ляо улсын дээлтэй адил боловч зөв энгэртэй, ихэнх нь ардаа оноогүй байх ажээ (Эрдэнэбат 2018). Хятанчуудын эрт үеийн дээл нь голчлон арьсаар хийгдсэн бөгөөд нэхий дээл, савхин дээл гэсэн хоёр гол төрөл байжээ. ӨМӨЗО-ны Хишигтэн хошууны Эрбади (克什克腾旗二八地) дахь Ляогийн бунхны чулуун хашлагын дотор талын хананд “Хятан мал малжиж буй зураг” (契丹族草原放牧图) гэдэгт дүрсэлсэн малчид нэхий малгай, нэхий дээлтэй, бүс бүслэн, гутал өмсөж, богино ташуур барьж мал малжиж байгааг зурсан байдаг.



Зураг 1. Сюанхуа дахь Ляо улсын бунхны ханын зураг “Цай бэлтгэх зураг”
(Хэбэй мужийн соёлын дурсгалт хүрээлэн, 2001)



Зураг 2. Аохань хошуун дахь Яншаны (敖汉旗羊山) оршуулгын газрын (Аохань хошууны музей 1999) 3-р бунхны баруун хананд байгаа хоол хийх зураг



Зураг 3. Ляо улсын бунхнаас олдсон дээлийн арын оноо (Умард Хятадын эртний үндэстний хувцасны судалгаа. 3-р боть)

Түүнээс гадна, Монгол Улсын Баянхонгор аймгийн Дугуй Цахир, Ховд аймгийн Үзүүр гялангаас олдсон X-XII зууны зургаан дээлийг үзэхэд хийц загварын хувьд цөм Ляо улсын дээлтэй адил боловч зөв энгэртэй, Дугуй Цахираас олдсон эсгий дээл нь ардаа оноотой байх ажээ (Эрдэнэбат 2018).

Хятаны буруу энгэртэй дээл бол тэдний эртнээс уламжилсан хувцасны онцлог хэв маяг юм. Буруу энгэртэй гэдэг нь дотуур энгэрийг баруун тийш дарж гадар энгэрийг түүний дээгүүр зүүн тийш зөрүүлэн дарж өмсөх дээлийг хэлдэг. Археологи, угсаатны судлалын баримтаар хамгийн эртний бүдүүлэг хувцасны хэлбэр нь тэгш өнцөгт материалын голд нүх гаргаж, тэр нүхээр толгойгоо гарган өмсөж, цээж нуруундаа хоёр хэсэг болгон унжуулж бэлхүүсээрээ бүс бүслэн өмсдөг хувцас байжээ. Хожим нь өмсөж, тайлахад хялбар болгохын тулд урд хэсгийг хоёр хувааж, давхар палет үүсгэсэн. Дараа нь биеийн дулааныг хадгалах ба энгэр цээжээ ил задгай байлгахгүйн тулд урд талын хоёр энгэрийг томруулж, давхарлан зөрүүлж өмсдөг хэлбэр буй болсноор зүүн, баруун энгэртэй дээлийн хэлбэр хөгжсөн байна.

Хятан дээл нь ихэвчлэн буруу энгэртэй, мөн ардаа оноотой байдаг. Энэ нь хүний хөлийн хөдөлгөөнийг хязгаарладаггүй бөгөөд морь унахад маш тохиромжтой байдаг. Энэ онцлог нь Хятаны язгууртан ноёдоос эхлээд энгийн цэрэг дайчдын дээлэнд өргөн хэрэглэгддэг, үйл ажиллагааны практик шаардлага төдийгүй Хятан хувцасны гоо зүйн өвөрмөц хэв маягийг бүрдүүлжээ. Дээлийн оноог ихэвчлэн зурвас хүрээ, нарийн оёдол хатгамалаар

чимэглэдэг. Хойд Ци улсын үеийн Лу Руйгийн бунхны ханын зурагт хүмүүсийн өмссөн дугуй захтай буюу зөрүү захтай дээл нь хажуу ба ардаа оноотой байдаг. Хүмүүсийн өмссөн дээлийн нурууны дунд шугамын доод талд тэгш хэмтэй оноо харагдана. Энэ төрлийн дээл нь Зүрчин, Даншяны хувцсанд ч байдаг бөгөөд нүүдэлчдийн хувцасны онцлог болно. Хятан болон Зүрчин дээлийн хэлбэр өөр өөрийн онцлогтой байсан. Зүрчин дээл нь ихэвчлэн бэлхүүсээс эхэлдэг өндөр оноотой, харин Хятан дээл харьцангуй доогуур оноотой. Даншян дээлийн оноон өндөр нь Хятан дээлийнхтэй ойролцоо. Зүрчин дээл нь хоёр хажуудаа илүү өргөн, Хятан дээл нь нарийн оноотой. Үүнийг, тухайн цаг үеийн зураач Ли Занхуагийн (李赞华) “Буга агнаж буй” гэдэг зураг (获鹿图) зэрэг олон бүтээлээс харж болно.

Ляо улсын үеийн археологийн олдворуудаас олон Хятан дээл олдсон. Хятан дээлийн урт нь ерөнхийдөө 140-155 см, захын өргөн нь 100-115 см байдаг. Олдсон биет олдвор Хятан дээл нь маш олон төрлийн хэв маягтай байсныг харуулж байна. Дээлийн заам буюу захын төрлөөр ангилвал дугуй захтай дээл, солбицсон буюу налуу захтай дээл; ханцуйны уртаар ангилсан бол урт ханцуйтай дээл, богино ханцуйтай дээл байна; ангархай загвараар ангилвал хажуугийн ангархай дээл, араар ангархай дээл гэж байна.

Бодит статистик мэдээллээс харахад Хятан дээлний “нарийн байдал” нь хятад дээлтэй харьцуулахад голчлон ханцуйвч, цээжний өргөнтэй холбоотой байдаг. Олдсон Хятан дээлний ханцуйвч нь ихэвчлэн 15 см буюу 16 см өргөн, цээжний өргөн нь 62-86 см,

хамгийн түгээмэл нь 68, 70 см, тухайлбал, Дайчинтал (代钦塔拉) булшнаас олдсон Хятаны язгууртны дээл, Елюй Южингийн (耶律羽之) бунханаас олдсон алтан хээтэй язгууртны дээл, хүүхдийн өмсдөг дээл ч мөн адил хэлбэртэй боловч тэдгээрийг пропорциональ хэмжээгээр багасгасан байдаг. Шяожинзи булшнаас амаараа 10.5 см, цээжин хэсэг нь 39 см өргөн ягаан торгон дээл олдсон байна. Шяожинзи (小井子) булшнаас ханцуйвч нь 10.5 см, цээжний өргөн нь 39 см бор өнгийн торгон дээл олдсон байна. Өргөн цээжтэй гурван дээлийг Швейцарийн Абегт-Штифтунг төв, Хонг Конгийн Мэндисуан (梦蝶轩) төвд хадгалж байгаа бөгөөд цээжний өргөн нь 84-86 см байна. Дайчинтала булшнаас харьцангуй эрт үеийн дээл олдсон байна. Энэ нь солбицсон буюу налуу захтай, зүүн энгэртэй, ханцуйнаас бусад цээжнээс доош хэсэг нь боргоцой буюу дэвүүр хэлбэртэй маш өргөн байв. Зарим эрдэмтэд үүнийг “өргөн дээл” гэж нэрлэдэг. Энэ төрлийн дээл харьцангуй ховор бөгөөд ханын зурагт харагдахгүй байна (Бао Миншин 2013).

Ляо улсын Хятан үндэстний хүмүүс зүүн, баруун энгэртээ товч, гогцоотой, тусгай төрлийн дээлтэй байсныг тэмдэглэх нь зүйтэй. Зүүн энгэр ч бай, баруун энгэр ч бай товчилж өмсөх боломжтой бөгөөд өмссөн хүн гадна болон дотор талын энгэрээ чөлөөтэй сольж болно. Нийтдээ хоёр хэсэг байна. Нэг нь Азийн нэхмэлийн судалгаа, баримтжуулалтын холбоо (A.E.D.T.A)-ны цуглуулсан алтан хаггамал, луу хээтэй шар торгон дээл юм. Нөгөө нь ӨМӨЗО-ны Баарин зүүн хошуун (巴林左旗) дахь Шанжин суурингийн


баруун хойд талын ууланд байдаг Ляогийн булшнаас олдсон Шиэжи хээтэй бор торгон дээл бөгөөд Ляо Шанжин музейд хадгалагдаж байна. Дээлийн урт 146 см, ханцуйны урт 201 см, захын өргөн 88 см, ханцуйвч 16 см, арын ангархай нь 80 см өндөртэй. Дээлийн зүүн ба баруун захын харгалзах байрлалд гурван товчлуур байгаа бөгөөд нэг нь захын хэсэгт, нөгөө хоёр нь захын захад байрладаг (Ляо Соёлын Судалгааны Нийгэмлэг 2009). Өвөр Монголын Өөртөө Засах Орны музейд хадгалагдаж байгаа умард төрийн үеийн хүрэн өнгийн налуу захтай хөвөн дээл бий. Зүүн ба баруун энгэрийн ирмэг дээр цагаан зангиа оосор байх ба үүний дагуу суганы ойролцоо зүүн, баруун талд оосор хадаж уях зориулалттай хийжээ. Хэдийгээр энэ булшны эзэн нь тодорхойгүй ч зүүн, баруун талдаа сольж уяж болдог энэ хэв маяг нь Умард төрийн үед, аль хэдийн гарч ирсэн эсвэл археологийн баримтуудыг цаашид илрүүлэхийг хүлээж байх нь гарцаагүй юм. Энэ хэв маягийг 4-5 зуун жилийн дараа ч Хятанчууд хэрэглэж байсан нь нүүдэлчин ард түмний ахуй заншилд хэр нийцэж байсныг илтгэнэ (Хятадын Умард цөөн тоот үндэстний хувцасны судалгаа 2013).

Дүгнэлт

Хувцас бол улс үндэстний бэлгэдэл, хүн төрөлхтний соёлын өвөрмөц илрэл юм. Хувцасны хувьсал, хөгжил нь улс төр, эдийн засаг, соёл зэрэг нийгмийн баялаг утгыг тусгаж, тухайн үеийн материаллаг болон оюун санааны цогц тусгал болдог. Хувцас нь



Зураг 4. Ли Занхуа. “Буга намнаж буй” хэмээх зураг. 24.6 х 78.9 см. Метрополитан урлагийн музей



Зураг 5. Өвөр Монголын Өөртөө Засах Орны музейд хадгалагдаж байгаа умрад төрийн үеийн хүрэн өнгийн налуу захтай хөвөн дээлын тайлбар зураг (Хятадын Умард цөөн тоот үндэстний хувцасны судалгаа 2013)

үндэсний онцлог шинж чанар, зан заншил, амьдрах орчин, амьдралын хэв маягийг илэрхийлнэ. Хятан нарын хувцасны онцлог нь тухайн үндэстний үүсэн бий болж, хөгжих явцад бусад үндэстний хувцасны соёлтой тасралтгүй харилцан солилцож, нэгдэн орсноор бүрэлдэн бий болжээ. Одоо археологийн малтлагын мэдээллээс үзэхэд Хятан нар хувцасныхаа үндэсний онцлогоо хадгалахад анхаарч байсан бөгөөд Хятад суурин соёл, хувцасны соёлтой харьцаж, солилцсоны дараа Хятад үндэстний нэхмэлийн технологид суралцсан байна. Хувцасны материалыг арьс шир, ноос ноолуур зэрэг үслэг эдлэл ба торго, даавуу мэт нэхмэл эдлэлийг хослон хэрэглэх болсон ч уламжлал хэвээр хадгалагдан үлдэж, үндэсний хувцсанд уламжлалт түүхий эдээ ашигласаар байжээ.

Хятан нар бэлчээр ус даган нүүдэллэж мал маллах амьдрал, ан агнуур хийхээс болж Хятад үндэстнийхээс ялгаатай хувцас хэрэглэлийн соёл бүрэлдэн тогтсон байдаг. Хятан хувцас нь нарийн биетэй, буруу энгэртэй, ардаа оноотой, богинохон хормойтой байдаг нь морь унах, нум сум харвахад тохиромжтой. Түүнчлэн дугуй заамтай, ар талдаа оноотой дээл нь Хятан үндэстний төлөөллийн хувцас бөгөөд Сүй, Тан, Сүн улсын Монголын өндөрлөгийн нүүдэлчдийн хувцасны нийтлэг хэлбэрийг хадгалжээ. X-XIII зууны үед Монголын өндөрлөгийн Хятан, Зүрчин, Дансян, Монгол гэх мэт хүчирхэг үндэстний хувцсанд нийтлэг зүйл их байсан нь тэдний амьдрах орчин, үйлдвэрлэлийн арга барил ижил төстэй, түүнчлэн байлдан дагуулалт, худалдааны солилцоо, овог аймгуудын хоорондын соёлын солилцоо зэрэг нь соёлын харилцан нөлөөллийн гэрч юм.

Abstract

Several issues in the study of Khitan clothing

Sunina

The Mongolian Plateau has been home to nomadic peoples since ancient times. Influenced by the harsh climate and a nomadic lifestyle, these groups developed distinctive ethnic attire characterized by the use of fur as the primary material, along with a two-piece design of upper garment and trousers, markedly different from the agricultural communities of the Central Plains. The nomadic peoples of the Mongolian Plateau encompassed a variety of ethnic groups that evolved, merged, and diverged due to factors such as war and politics, resulting in the formation and subdivision of new ethnicities and branches. While specific variations in attire emerged, the shared geographic environment and lifestyle fostered common features in their clothing: herding and hunting necessitated agile movement and well-fitting garments, while traversing the vast steppes required shorter, tighter robes and long boots for practicality.

This paper traces the development and evolution of Khitan attire during the formation of the Khitan ethnic group. It examines the structural design of their clothing, compares it with the attire of the Tangut, Jurchen, Mongol, and Han peoples, and explores the origins of the Khitan clothing style in the 10th–13th centuries, with particular attention to the Mongolian influences within Khitan attire.

Keywords: Khitan, clothing, tomb murals

Ном зүй

Аохань хошууны музей (1999). Аохань хошууны Яншаны дахь 1-3 дугаар Ляо булшны товч тайлан, Өвөр Монголын Соёлын дурсгал, Археологи судлал, 1-38.

Бээжингийн соёлын дурсгалт зүйлсийн хэвлэлийн газар (2001), х 8-63. 敖汉旗博物馆: 《敖汉旗羊山1—3号辽墓清理简报》, 《内蒙古文物考古》1999年第1期, 第1—38 页.

Бу Айчин (2020). “Хятадын археологи” сэтгүүлийн 5-р дугаарт 10-13-р зууны үеийн умард нүүдэлчдийн хувцасны хэв маягийн талаар судалгаа: Хятаны жишээн дээр, 109-110. 吴爱琴. 2020, 《华夏考古》年第5期以契丹为例谈10—13世纪北方游牧民族服饰风格, 109—110页

Е Лонгли (1986). Хятан шастир. Тайбэй. Арилжааны хэвлэлийн газар. 叶隆礼. 1986, 契丹国志: 卷二三: 兵马制度, 台北: 商务印书馆, 1986.

Жун Чунхуй (2019). Анги давхарга ба ёс зүй - Цингийн өмнөх үеийн хувцасны судалгаа. Ордны музей. Тайвань. 2019 оны 8-р сар. 19. 钟春晖. 等级与伦理——先秦时代的服饰观. 故宫博物院. 台湾. 2019 年第19页.

Хэбэй мужийн соёлын дурсгалын судалгааны хүрээлэн (2001). Сюаньхуа дахь Ляо булш: 1974-1993 оны археологийн малтлагын тайлан (1-р боть), Бээжингийн соёлын дурсгалт зүйлсийн хэвлэлийн газар, 8-63. 河北省文物研究所: 《宣化辽墓: 1974—1993 年考古发掘报告》(上册), 北京: 北京文物出版社, 2001, 第8—63页

Редакцийн хэлтсээс найруулсан (1992). Хятадын соёл иргэншлийн түүх: Сүн, Ляо, Жинь үеийн түүх. 5-р бүлэг “Күнзийн суртлын тархалт ба боловсролын хөгжил”, 104. 编辑部编辑. 1992年, 中国文明史, 宋辽金时期. 辽代, 第五章, 〈儒学的传播与教育的发展〉, 第104页

Тод (1974). Ляогийн түүх. Ивэй Жи 2-р боть. Бээжин. Жунхуа номын компани, 905, 脱脱. 1974, 辽

史: 卷五六: 仪卫志二. 北京. 中华书局, 905页

У Байчун (1990). Суожу. Монголын эзэнт гүрний товч түүх. Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо, 15. 蒙古帝国简史, 吴柏春, 锁柱编著, 内蒙古文化出版社出版, 1990年, 第15页

Шэн Куо (1984). Шинин элч Хятанд аялсан тэмдэглэл, Бээжин. Жунхуа номын компан, 123. 沈括. 1984. 熙宁使契丹图抄. 北京. 中华书局, 123页

Эрдэнэбат, У. (2018). Монгол хувцас түүх соёлын дурсгал болох нь. - Нүүдэлчдийн торгон урлал. - УБ., 2018, 26-57.40

Ян Руовэй (1992). “Хятан улсын улс төр, цэргийн тогтолцооны судалгаа” 2-р бүлэг “Албан ёсны тогтолцоо ба засаг захиргааны тогтолцоо”, 201. 杨若薇 (1992年): 《契丹王朝政治军事制度研究》第二篇〈官制及行政制度〉, 201页.

Ван Гүөчин(2009): “Ляо улсын уламжлалт дээл—Шиэжи хээтэй торгон дээл”, Ляо Шанжин Хятан Ляогийн соёл судлалын нийгэмлэг, Ляо Шанжин Хятан Ляогийн соёлын эрдэм шинжилгээний анхдугаар симпозиум, ӨМӨЗО-ны Соёлын хэвлэл, 228. 王国庆: 《从獬豸纹紫绶袍看辽代传统袍服》, 载辽上京契丹·辽文化研究会编: 《首届辽上京契丹·辽文化学术研讨会论文集》, 内蒙古文化出版社2009年版, 第228页.

Бао Миншин (2013). Хятадын Умард цөөн тоот үндэстний хувцасны судалгаа (Хятан 3-р боть). Дунхуа их сургуулийн хэвлэл. 99-100. 包铭新. 中国北方少数民族服饰研究(契丹卷3). 东华大学出版社. 2013. 第99—100页

Received: May 12, 2025; Revised: May 26, 2025;

Accepted: June 13, 2025

